



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
АКТ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Р.ЭРДЭНЭБҮРЭН ТАНАА

2015.06.05 № 2/28 УАГ-ГАГ/2015/01-ГА

Төлбөрийн акт тогтоох тухай

Барилга хот байгуулалтын сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийх явцад "Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрологи, газар хөдлөлт, техникийн судалгаа боловсруулах" ажлыг хэрэгжүүлэх явцад доорх зөрчил илэрлээ.

Гүйцэтгэгч Одон орон, геофизикийн судалгааны төв нь 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр "Улаанбаатар хот болон Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг хийх" зөвлөх үйлчилгээний 21 тоот 295.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, гэрээт ажлын гүйцэтгэлийг хавсралт 5-д заасны дагуу "эхний шатны гүйцэтгэлийг 2013 оны 1 дүгээр сар, дунд шатны гүйцэтгэлийг 2013 оны 12 дугаар сар, 2014 оны 12 дугаар саруудад" явцын хяналт хийгдсэн тайланг ирүүлэхээр байсан боловч хугацаандаа ирүүлээгүй байна. Энэ нь Иргэний хуулийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтыг зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Иргэний хууль болон ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцлийн 2.3, 3.56, 8.2.5-д заасныг үндэслэн төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцроосон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.1 хувиар тооцсон алданги болох 19'484'970 /арван есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга есөн зуун далан/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дах улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2015 оны 9 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлж улсын төсвийн орлого болгох,
2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2015 оны 9 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг БХБЯ-ны


Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэн, СЭЗХ-ийн дарга Д.Хасар нарт хариуцуулав.

ТОГТООСОН:

ҮАГ-ЫН ГАГ-ЫН
АХЛАХ АУДИТОР



Б.САРУУЛ




АКТ

ЗӨВШӨӨРСӨН:

БХБЯ-НЫ СЭЗХ-ИЙН ДАРГА

Д.ХАСАР



ЕРӨНХИЙ НЯТГЛАН БОДОГЧ

Д.ЛУВСАН

